Бүрэгхангай сумын Засаг дарга үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хуулийг дээдэлж, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх, төрийн албыг “Мерит зарчимд тулгуурлан чадавхжуулж, мэргэшүүлэх сургалтын хүрээг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулах замаар төрийн албаны мэргэшсэн тогтвортой байх нөхцөлийг хангаж төрийн захиргааны мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлж, төрийн ажил үйлчилгээг иргэдэд ил тод хөнгөн шуурхай хүргэх таатай орчныг бүрдүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон ажилласан байна. Үүнд:

- ✓ Нутгийн захиргааны байгууллагын удирдлагыг бэхжүүлэх,
- ✓ Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баримтлах,
- ✓ Сумын эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх,
- ✓ Сумын нийгмийн салбарын хөгжлийг ахиулах,
- ✓ Төв, суурин газрын тохижилт, нийтийн үйлчилгээний чанарыг сайжруулах,
- ✓ Захиргааны үйл ажиллагаа, захиргааны үйлчилгээний үр дүн, чанар, үр нөлөөг дээшлүүлэх,
- ✓ Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын цар хүрээг нэмэгдүүлэх

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бүрэгхангай сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бүрэгхангай сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Байгууллагын болон санхүүгийн хяналт аудитын албанаас 2020 онд харьяа байгууллагуудад дотоод аудит хийгээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн батлагдсан төсвийн 3,156,900.3 мянган төгрөгийн 1 хувь буюу 31,569.0 мянган төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 707,129.9 мянган төгрөг болж, 214,726.1 мянган төгрөгөөр буюу 43.6 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Үлдэгдэлд эдлэх хувь
Төрийн сангийн харилцах	492,403.8	707,129.9	214,726.1	100.0
Дүн	492,403.8	707,129.9	214,726.1	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр				
Байгаль хамгаалах сан	243,914.3	229,920.3	(13,994.0)	32.5
ЖДҮДэмжих сан	7,418.9	15,942.0	8,523.1	2.3
Сум хөгжүүлэх сан	16,721.7	31,823.8	15,102.1	4.5
Орон нутгийн хөгжлийн сан	150,610.8	158,558.7	7,947.9	22.4
Орон нутгийн ерөнхий орлого	73,738.2	270,885.0	197,146.8	38.3
Дүн	492,403.8	707,129.9	214,726.1	100.0

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, жолоочийн тооцооны хуудасгүй, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Тухайлбал: Сумын ЗДТГ 1,196.8 мянга, Эрүүл мэндийн төв 4,052.0 мянган төгрөг.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 214,874.6 мянга, эцсийн үлдэгдэл 208,119.5 мянган төгрөг болж 6,755.1 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Үлдэгдэлд эдлэх хувь
Байгууллагаас авах авлага	18,029.3	25,089.1	7,059.8	12.1
Хувь хүнээс авах авлага	196,845.4	183,030.4	(13,815.0)	87.9
Дүн	214,874.6	208,119.5	6,755.1	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр				
Сумын ЗДТГ	2,126.7	11,686.6	9,559.9	5.6
ЖДҮД сан	10,022.1	10,022.1	-	4.8
Сум хөгжүүлэх сан	185,725.8	171,910.8	13,815.0	82.6
Орон нутгийн хөгжлийн сан	7,000.0	7,000.0	-	3.4
Цэцэрлэг	-	7,500.0	7,500.0	3.6
Эрүүл мэндийн төв	10,000.0	-	(10,000.0)	-
Дүн	214,874.6	208,119.5	6,755.1	100.0

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансанд олон жилийн насжилттай сум хөгжүүлэх сангийн 21 зээлдэгчийн 82,915.2 мянга, ЖДҮДСангаас олгосон зээлдэгчийн бүртгэлд нэрсээр байхгүй 10,589.1 мянга, ЗДТГ-ын эзэн холбогдогч нь тодорхойгой хувь хүнээс авах 1,097.4 мянга, ОНХС-ийн ажлаа хийж гүйцэтгээгүй Газрын гүний ус ХХК-ий 7,000.0 мянган төгрөгийн авлага байна. Эдгээр нь жижиг дунд үйлдвэрлэл хөгжихгүй, ажлын байр нэмэгдэхгүй, сангийн хөрөнгө багасах, зээлийн эргэлт удаашрах үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

- Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэж, харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. Тухайлбал: Хүүхдийн цэцэрлэг 7,500.0 мянган төгрөг.
- 1999-2012 онд үүссэн олон жилийн насжилттай авлагыг хууль, журмын дагуу эзэн холбогдогчийг нь тодорхойлох ажил зохион байгуулаагүй, УСНББОУС, НБББББ-д нийцүүлэн найдваргүй авлагын нөөц үүсгэж хорогдуулаагүй авлагууд байна. Тухайлбал: Засаг даргын тамгын газар 1,097.4 мянга, ОНХС 7,000.0 мянга, ЖДҮДС 10,022.1 мянган төгрөг байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 225,018.7 мянга, эцсийн үлдэгдэл 234,638.5 мянган төгрөг болж, 11,095.8 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Үлдэгдэлд эдлэх хувь
Тусгай зориулалтын материал	19,946.0	7,693.7	(12,252.3)	3.3
Эм боох материал	121.6	12,852.9	12,731.3	5.4
Бичиг хэргийн материал	2,953.2	4,917.2	1,964.0	2.1
Аж ахуйн материал	158,962.1	181,671.1	22,709.0	76.9
Сэлбэг хэрэгсэл	3,950.0	4,585.0	635.0	1.9
Барилгын засварын материал	605.6	134.0	471.6	0.1
Хүнсний материал	35,048.2	18,660.8	(16,387.4)	7.9
Мал амьтад	1,470.0	1,470.0	-	-
Бусад хангамжийн материал	1,962.0	4,129.7	2,161.7	1.7
Дүн	225,018.7	236,114.5	11,095.8	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр				
Сумын ЗДТГ	13,395.6	28,326.3	14,930.7	12.0
Сумын ИТХ	2,100.9	2,715.9	615.0	1.2
Соёлын төв	7,000.0	7,565.0	565.0	3.2
Ерөнхий боловсролын сургууль	64,062.9	72,834.8	8,771.9	30.8
Цэцэрлэг	84,587.9	72,497.1	12,090.8	30.7
Эрүүл мэндийн төв	53,871.4	52,175.4	1,696.0	22.1
Дүн	225,018.7	236,114.5	11,095.8	100.0

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 202,964.8 мянга, хандиваар 20,779.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 192,219.1 мянга, шилжүүлсэн 14,167.4 мянга, байгууллагын өмч хамгаалах комиссын шийдвэрээр акталсан 6,259.4 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Бараа материалын тайлангийн үлдэгдэлд тайлант оны эцэст 236,114.5 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, барилгын засварын материал, бусад хангамжийн материалыг төсвийн хэмнэлтийг улс, орон нутгийн буцаан төсөвт төвлөрүүлэхгүй шалтгаанаар нөөцөлсөн байна. /ЗДТГ газар 28,326.4 мянга, ЭМТ 52,175.4 мянга, ЕБСургууль 72,834.8 мянга, цэцэрлэг 72,497.1 мянга, ИТХ 2,715.9 мянга, соёлын төв 7,564.9 мянган төгрөг/

Аудитын илрүүлэлт:

- *Бараа материалын тайлангийн дансны үлдэгдэл тус бүрээр тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй. Тухайлбал: Эрүүл мэндийн төв,*
- *Бараа материалын тайланд үнэ төлбөргүй авсан материалыг тайланд тусгаагүй зарцуулсан. Сумын ИТХ 125.0 мянган төгрөг.*

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,260,077.3 мянга, эцсийн үлдэгдэл 6,576,701.9 мянга төгрөг болж 1,316,624.6 мянган төгрөгөөр буюу 25.0 хувиар өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өссөн+ Буурсан -	Үлдэгдэлд эдлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	4,239,779.7	5,440,854.2	1,201,074.5	82.7
Хуримтлагдсан элэгдэл	(342,864.3)	(541,579.4)	(198,715.1)	(8.2)
Авто-тээврийн хэрэгсэл	295,737.9	295,737.9	-	4.5
Хуримтлагдсан элэгдэл	(187,644.5)	(209,852.4)	(22,207.9)	(3.2)
Машин тоног төхөөрөмж/компьютер/	721,348.4	794,121.7	72,773.9	12.1
Хуримтлагдсан элэгдэл	(213,573.6)	(223,803.3)	(10,229.7)	(3.4)
Тавилга, аж ахуйн эд хогшил	223,421.0	251,394.1	27,973.1	3.8
Хуримтлагдсан элэгдэл	(96,452.2)	(88,180.7)	8,271.5	(1.3)
Зам, гүүрийн байгууламж	365,999.9	611,530.1	245,530.2	9.3
Хуримтлагдсан элэгдэл	(42,516.6)	(58,566.6)	(16,050.0)	(0.9)
Бусад үндсэн хөрөнгө	232,986.4	253,071.7	20,085.3	3.8
Хуримтлагдсан элэгдэл	(39,486.5)	(54,888.9)	(15,402.4)	(0.8)
Ном	25,167.5	27,872.5	2,705.0	0.4
Программ хангамж	300.0	300.0	-	0.0
Хуримтлагдсан элэгдэл	78,848.5	80,499.9	1,651.4	1.2
Бусад биет бус хөрөнгө	(974.3)	(1,808.9)	(834.6)	(0.0)
Дүн	5,260,077.3	6,576,701.9	1,316,624.6	100.0
Сумын ЗДТГ	3,102,041.7	3,278,758.2	176,716.5	49.9
Сумын ИТХ	2,227.8	6,582.6	4,354.8	0.1
Соёлын төв	212,290.9	203,419.5	(8,871.4)	3.1
Ерөнхий боловсролын сургууль	1,348,955.0	1,909,368.2	560,413.2	29.0
Эрүүл мэндийн төв	357,059.4	380,426.7	23,367.3	5.8
Цэцэрлэг	237,502.5	798,146.8	560,644.3	12.1
Дүн	5,260,077.3	6,576,701.9	1,316,624.6	100.0

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 63,634.4 мянга, балансаас балансад шилжүүлэн авсан 361,387.8 мянга, анхны өртөгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгийг дахин шинэчлэн үнэ тогтоосон 2,227.9 мянга, дээд шатны төсвийн захирагчаас хийгдсэн хөрөнгө оруулалт 20,838.5 мянга, үнэ төлбөргүй буюу хандиваар авсан 1,217,531.6 мянга төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 35,875.4 мянга, бусад байгууллагаруу балансаас балансын хооронд шилжүүлсэн 51,861.8 мянган төгрөгөөр тус тус хасагдснаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- *УСНББОУС-17 хэрэгжүүлээгүй үндсэн хөрөнгийн тайлангийн программ хангамжийн дансанд санхүүгийн программыг дансны давхар бичилт хийж орлого аваагүй, элэгдэл бодоогүй байна. Тухайлбал: Засаг даргын тамгын газар.*

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,690.5 мянган, эцсийн үлдэгдэлгүй болж 2,690.5 мянган төгрөгөөр буюу 100 хувь бууруулан өргүй болсон байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өссөн+ Буурсан -	Үлдэгдэлд эдлэх хувь
Байгууллагад төлөх өглөг	2,690.5	-	(2,690.5)	-
Дүн	2,690.5	-	(2,690.5)	100.0

Сумын ЗДТГ	1,437.4	-	(1,437.4)	-
Цэцэрлэг	253.1	-	(253.1)	-
Орон нутгийн ерөнхий орлого	1,000.0	-	(1,000.0)	-
Дүн	2,690.5	-	(2,690.5)	100.0

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,189,683.9 мянга, эцсийн үлдэгдэл 7,728,065.7 мянган төгрөг болж, 1,538,381.7 мянга төгрөгөөр буюу 24.8 хувиар өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/мянган төгрөг/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт -/	Үлдэгдэлд эдлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,322,029.4	1,322,029.4	-	17.1
Хуримтлагдсан үр дүн	2,563,017.8	4,101,399.6	1,538,381.8	53.1
Өмнөх үеийн үр дүн	2,489,660.0	2,564,425.9	74,765.8	33.2
Тайлант үеийн үр дүн	73,357.7	1,536,973.7	1,463,616.0	19.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,304,636.7	2,304,636.7	-	29.8
Дүн	6,189,683.9	7,728,065.7	1,538,381.8	100.0
Сумын ЗДТГ	3,116,126.6	3,318,771.0	202,644.4	42.9
Сумын ИТХ	4,328.7	9,298.5	4,969.8	0.1
Соёлын төв	219,290.9	210,984.4	(8,306.5)	2.7
Ерөнхий боловсролын сургууль	1,413,017.9	1,982,203.0	569,185.1	25.6
Цэцэрлэг	321,837.4	878,143.8	556,306.4	11.4
Эрүүл мэндийн төв	420,930.7	432,602.1	11,671.4	5.6
ЖДҮДСан	17,441.0	25,964.1	8,523.1	0.3
Байгаль хамгаалах сан	243,914.3	229,920.3	(13,994.0)	3.0
ОНХСан	157,610.7	165,558.8	7,948.1	2.1
Сум хөгжүүлэх сан	202,447.5	203,734.7	1,287.2	2.6
Орон нутгийн ерөнхий орлого	72,738.2	270,885.0	198,146.8	3.5
ДҮН	6,189,683.9	7,728,065.7	1,538,381.8	100.0

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 7,728,065.7 мянган төгрөг болж 1,538,381.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны элэгдлийн зардал болон хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 2,304,636.7 мянган төгрөг болж тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан үр дүн 4,101,399.6 мянган төгрөг болж 1,538,381.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүн эерэг үзүүлэлттэй тайлагнаснаас шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Орлогын төлөвлөгөөг 101,860.0 мянган төгрөгөөр баталж, 317,222.1 мянган төгрөгийг бүрдүүлэн, 215,362.1 мянган төгрөгөөр буюу 211.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орлогын гүйцэтгэл

ЭЗА	Үзүүлэлт	/мянган төгрөг/		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт +, хэмнэлт-
1	Урсгал орлого	101,860.0	317,222.1	215,362.1
11	Татварын орлого	79,360.0	280,982.8	201,622.8
110	<i>Орлогын албан татвар</i>	<i>41,360.0</i>	<i>64,986.2</i>	<i>23,626.2</i>
110002	Үйл ажиллагааны орлого	500.0	4,680.2	4,180.2
110003	Хөрөнгийн орлого	25,860.0	26,728.6	868.6

110008	Шууд бус орлого	15,000.0	33,577.4	18,577.4
113	<i>Хөрөнгийн албан татвар</i>	3,500.0	2,456.0	(1,044.0)
113002	Бууны албан татвар	3,500.0	2,456.0	(1,044.0)
118	<i>Бусад татвар, төлбөр, хураамж</i>	10,500.0	14,699.2	4,199.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,500.0	14,699.2	4,199.2
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,500.0	4,450.0	1,950.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,000.0	10,249.2	2,249.2
1181	<i>Газрын төлбөр</i>	-	149,344.8	149,344.8
118101	Газрын төлбөр	-	149,344.8	149,344.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	24,000.0	49,496.6	25,496.6
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	10,000.0	18,334.6	8,334.6
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	14,000.0	31,162.0	17,162.0
12	Татварын бус орлого	22,500.0	36,239.3	13,739.3
120	<i>Нийтлэг татварын бус орлого</i>	22,500.0	36,239.3	13,739.3
120002	Хүүгийн орлого	13,000.0	25,477.6	12,477.6
120005	Түрээсийн орлого	4,500.0	2,464.5	(2,035.5)
120009	Бусад орлого	5,000.0	8,297.1	3,297.1

Эх сурвалж Бүрэгхангай сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл үйл ажиллагааны орлого 836.0 хувь, хадгаламжийн хүүгийн орлого 3.2 хувь, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 78.0 хувь, хог хаягдлын хураамжийн орлого 28.1 хувь, гоожингийн орлого 83.3 хувь, хүүгийн орлого 96.0 хувь, байгалийн нөөц ашигласны төлбөр 106.2 хувь, бусад орлого 65.9 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.

Бууны албан татвар 29.8 хувь, түрээсийн орлого 45.2 хувиар тус тус тасарсан байна.

Орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэхэд иргэн бүрт олгож байгаа хувьцааны ногдол ашиг, иргэдийн хадгаламж өссөн, үл хөдлөх хөрөнгө өмнөх жилүүдээс их арилжаалагдснаас нөлөөлсөн байна. Харин орлогын төлөвлөгөө бодитой төлөвлөгдөөгүйгээс шалтгаалан орлого тасарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Бууны албан татвар 1,044.0 мянга, түрээсийн орлого 2,035.5 мянган төгрөгөөр тасарсан байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 44,360.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмээгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахгүй байна.
- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчин батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, цалингийн тооцооллыг зөрүүтэй тооцож олгосон байна. Тухайлбал: Цэцэрлэг 2,543.5 мянга, ЗДТГ 830.0 мянган төгрөг.
- Тайлант хугацааны элэгдлийн зардлыг дутуу тооцоолж, тайлагнасан. Тухайлбал: Сумын ИТХ 758.3 мянган төгрөг.
- ТБОНӨХБАҮХАТ хуулийг хэрэгжүүлээгүй тендерт шалгарч гэрээ байгуулаагүй 5 компаниас эм, эмийн хэрэгслийг бэлтгэсэн байна. Тухайлбал: Эрүүл мэндийн төв.
- Сангийн сайдын 2006 оны 55 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг бүлэг

хооронд гүйлгэн зарцуулсан. Тухайлбал: Соёлын төв, Сумын ИТХ 150.6 мянган төгрөг.

- Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тэтгэмжийн зардлыг байгууллагын дарга өөрийн дансруу шилжүүлсэн байна. Тухайлбал: эрүүл мэндийн төв 300.0 мянган төгрөг.
- УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаагүй тооцоолсон цалингийн зардлыг цалингийн өглөг дансаар дамжуулаагүй, дансны давхар бичилтээр ажил гүйлгээг бүртгээгүй, шууд зардлаар бүртгэсэн байна. Тухайлбал: Цэцэрлэг 39,778.4 мянга,

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Бүрэгхангай сумын ИТХ-ын 2020 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 10/04 дүгээр хуралдааны тогтоолд сумын ЗДТГ 710.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 559.0 мянган төгрөгийг орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 151.0 мянган төгрөгөөр буюу 21.3 хувиар тасалсан байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Засаг даргын тамгын газар	710.0	559.0	151.0	78.7
ДҮН	710.0	559.0	151.0	78.7

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын ЗДТГ-ын орлого тасарсан нь ковид-19 цар тахал болж хол хорио тогтоогдсоноос шалтгаалжээ.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,254,315.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,254,315.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 361,981.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 4,616,297.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 3,421,193.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,421,193.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 825,997.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,312,470.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэгээр, 111,185.1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 25,202.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 656,010.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, үлдэх 490,327.5 мянган төгрөгийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 826,827.4 мянга, ОНХСангаас 95,637.2 мянга, тусгай зориулалтын шилжүүлэгээс 1,194,699.5 мянга, ЭМДСангаас 23,824.2 мянган төгрөгийг санхүүжүүлэн, 133,868.0 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 552.0 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 158.0 мянган төгрөгөөр тасарсан нь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин хол хорио тогтоогдсоноос шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,541,334.9 мянган төгрөг буюу 74.3 хувьтай байгаа нь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажилласан, урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйгээс шалтгаалсан байна. Үүнд:

- ✚ ЕБС, цэцэрлэгүүдийн халаалтын зардлыг дутуу халаасан,
- ✚ Урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг хойшлуулсан,
- ✚ Боловсролын байгууллагын хоол хүнс, үдийн цай, дотуур байрны зардал хэмнэгдсэнээс нөлөөлсөн байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 26,587.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 118,949.6 мянган төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээнд 533,185.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 422,074.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 11,847.9 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 130,029.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 107.0 мянган төгрөг нийт 141,984.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр 9,996.9 мянган төгрөгөөр тавилга эд хогшилыг цэцэрлэгт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад зардал, бараа үйлчилгээний бусад зардалд 103,504.5 мянган төгрөгийг ЗДТГ-т, Эрүүл мэндийн төвд ковид-19 холбоотойгоор бичиг хэрэг, тээвэр шатахуун, эм эмнэлэгийн хэрэгсэлд 16,490.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3.1 мянган төгрөгийг улсын төсөвт, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 10,589.1 мянган төгрөгийг буцаан авах авлагаар тайлагнасан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1045 мэдээллээс 967 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийн хугацаа болоогүй, 67 мэдээллийг хугацаа хоцроож, 55,876.5 мянган төгрөгийн өмч хөрөнгө захиран зарцуулах 14 мэдээллийг байршуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тухайлбал: ЕБС 20, Цэцэрлэг 20, Эрүүл мэндийн төв 24, төвлөрүүлэн захирагч 3.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтын төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг мэдээлээгүй байна. Тухайлбал: Байгаль хамгаалах сангийн А/63, А/38, А/81, А/107, А/106, А/117, А/146, А/163, А/172, А/174, А/192, А/212, А/138, А/211 хөрөнгө зарцуулах тухай захирамжууд.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	-	-	100
Нийт	3	-	3	-	-	-	100

Эх сурвалж: 2019 оны байгууллагын статистик мэдээ.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 тусгай сан, 3 байгууллага түүвэрт, 2 тусгай сан төсвийн төвлөрүүлэн захирагчтай хамт аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-2, “Хязгаарлалттай”-1 /цэцэрлэг/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 87,498.9 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илрүүлснээс 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн талаар залруулга хийгдээгүй.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар аудитаар 1 алдаа зөрчил илэрснийг дараах байдлаас шийдвэрлэв. Үүнд:

- Харьяа байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1045 мэдээллээс 967 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийн хугацаа болоогүй, 67 мэдээллийг хугацаа хоцроож, 55,876.5 мянган төгрөгийн өмч хөрөнгө захиран зарцуулах 14 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтуудыг тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтуудыг хэрэгжүүлэн мэдээллийг шийдвэрийг нөхөж байршуулан, цаашид алдаа дутагдлыг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

Төвлөрүүлэн захирагчид 87,498.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 65,999.5 мянган төгрөгийн 16 алдаа, зөрчил илрүүлснээс 2,233.3 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 3,373.2 мянган төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 40,975.2 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 20,301.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн Ерөнхийлөн захирагч төсвийн жилийн дундуур хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө оруулсан өөрчлөлт, хийсэн зохицуулалтынхаа гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх, Харин төсвийн Төвлөрүүлэн захирагч харьяа байгууллагуудынхаа худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг цаг хугацаанд нь дүгнэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Хууль, журмын хэрэгжилттэй холбоотой асуудал.

4.1.1 Илрүүлэлт: Засаг даргын тамгын газар 300.0 мянган төгрөгийн программ хангамжийн дансны давхар бичилтээр бүртгэл тайланд тусгаагүй, тухайн жилд элэгдэл бодоогүй байна. УСНББОУС-ыг хэрэгүүлээгүйгээс гадна Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.1.2 Эрсдэл: Хөрөнгө эзэнгүйдэж, дутагдах, тайлант хугацааны үр дүн буруу илэрхийлэгдэх.

4.1.3 Өгсөн зөвлөмж: УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж ажиллах, албан тоот ирүүлсэн.

4.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.

4.2.1 Илрүүлэлт: 1999-2012 онд үүссэн олон жилийн насжилттай 18,119.5 мянган төгрөгийн авлага байгаа нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлж өр, авлага үүсгэхгүй байх хуулийн шаардлагыг биелүүлээгүй байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 Эрсдэл: өр, авлагын насжилт нэмэгдэж, эзэнгүй болох.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны авлагыг барагдуулах, УСНББОУС дагуу найдваргүй авлагын нөөц үүсгэх.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж ажиллах, албан тоот ирүүлсэн.

4.3 ОРЛОГОТОЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.

4.3.1 Илрүүлэлт: Сумын төсвийн орлогоос бууны албан татвар 1,044.0 мянга, түрээсийн орлого 2,035.5 мянган төгрөгийг бүрдүүлээгүй, тасалсан байна. Энэ нь хэмжилт, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх заасан орон нутгийн төсөвт оруулах болон төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

4.3.2 Эрсдэл: Сумын төсвийн орлого бүрдэхгүй, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлж чадахгүйгээс өглөг нэмэгдэх.

4.3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогыг бодитой төлөвлөх, орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд дайчлан ажиллах.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах, албан тоот ирүүлсэн.

4.4 Дотоод хяналттай холбоотой асуудал.

4.4.1 Илрүүлэлт: Аудитаар нийт 65,999.5 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгө зүй зохисгүй, үр ашиггүй зарцуулагдах.

4.4.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах, албан тоот ирүүлсэн.

4.5 хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

4.5.1 Илрүүлэлт: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайлын 2017 оны 347 тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.5.2 Эрсдэл: Орлогыг нуун дарагдуулах, тайлагнахгүй байх.

4.5.3 Өгсөн зөвлөмж: НӨАТТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2,17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших.

4.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах, албан тоот ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Д.АНХБАЯР	Огноо: 2021/03/25
АУДИТЫН МЕНЕЖЕР	Ж.ЭНХЦООДОЛ	Огноо: 2021/03/25
БЭЛТГЭСЭН: АУДИТОР	Г.ЦЭРЭНЛХАМ	Огноо: 2021/03/25

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Бүрэгхангай сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Огноо: 2021.03.25	Аудитын нэр: Алдаа, зөрчлийн товч утга Бүрэгхангай сумын Засаг дарга	Мөнгөн дүн	Аудитын код: БУА-2021/2/СТА-ТТ3	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Аудитын байгууллагаас гаргасан шийдэл мянган төгрөгөөр Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Харьяа байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1045 мэдээллээс 967 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийн хугацаа болоогүй, 67 мэдээллийг хугацаа хоцроож, өмч хөрөнгө захиран зарцуулах 14 мэдээллийг байршуулаагүй байна.	0	Алдаа дутагдлыг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.	Засаг дарга, Санхүү албаны дарга	М.Бадам, М.Батцэнгэл
2	2020 онд авлага нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн өр, авлага үүсгэхгүй байх шаардлагыг биелүүлээгүй байна.	18,119.5	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	М.Бадам, М.Батцэнгэл
3	Сумын орлогоос бууны албан татвар 1,044.0 мянга, түрээсийн орлого 2,035.5 мянган төгрөгөөр тасарсан байна.	3,079.5	Төсвийн орлогыг бодитой төлөвлөх, орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд дайчлан ажиллах зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	М.Бадам, М.Батцэнгэл
4	Аудитаар нийт 65,999.5 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	65,999.5	Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	М.Бадам, М.Батцэнгэл
5	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн.	0	НӨАТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	М.Бадам, М.Батцэнгэл
6	ЗДТГ 300.0 мянган төгрөгийн программ хангамжийн дансны давхар бичилтээр бүртгэл тайланд тусгаагүй, тухайн жилд элэгдэл бодоогүй байна. УСНББОУС-ыг хэрэгүүлээгүйгээс гадна Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	300.0	УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	М.Бадам, М.Батцэнгэл
	Дүн	87,498.9			